

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд байгууллагын үйл ажиллагаатай холбогдох 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээний 2023 оны 11 дүгээр сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв. Үүнд:

**Арга хэмжээ:** Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх.

**Хэрэгжилт:** “Цахим визийн систем” (evisa.mn)-ийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаанд нэвтрүүлж, 36 улсын иргэнд үйлчилгээ үзүүлж эхэлсэн.

Засгийн газрын 2022 оны 178 дугаар тогтоол, 2023 оны 01 дүгээр тогтоолуудаар нийт 35 улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлж, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/09, А/53 дугаар хамтарсан тушаалаар 98 улсыг цахим виз олгох улсын жагсаалтад нэмснийг уг системд бүрэн нэвтрүүлж, нийт 99 улсын иргэнд цахим виз олгож байна. <https://www.evisa.mn/en> “Цахим визийн систем”-ийг нэвтрүүлэх арга хэмжээний санхүүжилт Гадаад харилцааны яамны төсөвт тусгагдаж шийдвэрлэгдсэн болно.

Энэ оны өссөн дүнгээр (11 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал) нийт 30586 иргэнд цахим виз олгосон бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр тогтоол болон Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/09, А/53 дугаар хамтарсан тушаалыг мөрдөж эхэлснээс хойш тайлант хугацаанд “Визийн мэдээллийн нэгдсэн сан” систем (evisa.mn)-ээр нийт 89 улсын 30050 гадаадын иргэнд цахим виз олгосон байна. /Хэрэгжилт 100 хувь/

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 11 дүгээр сард 100 хувьтай үнэлэгдлээ.

Цаашид арга хэмжээний үр дүнг бууруулахгүйгээр чанаржуулж, үр дүнг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР